



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 66.

Есөнбулаг сум

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Багшийн хөгжил” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулж, биелэлтийн явцыг жил бүрийн IV улиард багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

244

Тэргүүлэгчдийн
24 өдрийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 7 дугаар сарын
24 өдрийн 6 дугаар тогтоолын хавсралт

“БАГШИЙН ХӨГЖИЛ” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Боловсролын шинэчлэлийн хүрээнд багшийг хөгжүүлэх чиглэлээр үндэсний хэмжээнд хөтөлбөр хэрэгжиж, тодорхой үр дүнгээ өгсөн хэдий ч энэхүү шинэчлэл нь багшаас асар их мэдлэг, арга зүй, ур чадварыг шаардсаар байна.

Аймгийн ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, анагаах ухааны лицей сургуулийн нийт 1020 багшийн 56,8 хувь, сургуулийн өмнөх боловсролын 256 багшийн 41,8 хувь нь тэргүүлэх болон заах аргач зэрэгтэй бөгөөд зөвлөх багш 6 байна.

Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсрол, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, АШУҮИС-ийн лицей сургуульд нийт 1020 багш багшилж байгаагийн 29,5 хувь буюу 244 нь магистр зэрэгтэй багш нар байна. Харин доктор зэрэгтэй багш байхгүй, доктрантурт суралцаж байгаа 4 багш байна.

2016 оны байдлаар мэргэжил дээшлүүлэх 27 төрлийн сургалтад давхардсан тоогоор 2503 багш хамрагдсан бөгөөд ойролцоогоор нэг багш гурван удаа сургалтад хамрагдсан байна. Мөн онд багш нарт чиглэсэн зөвлөгөөн 6 удаа зохиогдож, давхардсан тоогоор 713 багш, эрдэм шинжилгээний хурал 1 удаа явагдаж 56 багш, хурал уулзалт 2 удаа зохиогдож 391 багш хамрагдсан бөгөөд нийт 36 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 3663 багш хамрагдсан байна.

“Багшийн хөгжил” сэдвээр давхардсан тоогоор 1200 багшийг хамруулан хэлэлцүүлэг явуулж, судалгаа авахад онолын мэдлэг арга зүй, ур чадварыг сайжруулах, тэргүүн туршлагыг түгээх, бүтээл туурвил, шинэ санаа санаачилгыг дэмжих нийтийн хүртээл болгох, баг, хамтын ажиллагааг сайжруулах багшийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх тулгамдсан асуудлууд байгаа нь тодорхойлогдсон.

Дээрх тоон үзүүлэлтүүд, хэлэлцүүлэг судалгааны дүнгээс харахад багшийн тасралтгүй хөгжлийг хангах, сургалтын чанарыг ахиулах чиглэлээр орон нутгийн нэгдсэн бодлого, хөтөлбөр боловсруулах хэрэгцээ зүй ёсоор үүсч байна.

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим

- 2.1. Багшийн хөгжлийн түвшин, эрэлт хэрэгцээ, сонирхолд тулгуурласан байна.
- 2.2. Боловсролын тухай хууль болон бусад бодлогын баримт бичиг хөтөлбөртэй нийцсэн байх
- 2.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь нээлттэй, хүртээмжтэй уян хатан чанартай байх
- 2.4. Тогтвортой хөгжлийн чиг хандлага, боловсролын дидактикийн онолын үндэс үндэсний болон орон нутгийн онцлогт нийцсэн байх
- 2.5. Мэдээлэл, харилцааны технологийн ололт амжилтыг ашиглах
- 2.6. Аймаг, сум, багийн багш нарын тэгш оролцоог хангах

Гурав. Хөтөлбөрийн зорилго

Багшийн бүтээлчээр хамтран ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэн, мэдлэг ур чадвар, эерэг хандлагыг дэмжин, цогцоор нь хөгжүүлж, манлайллыг нэмэгдүүлснээр Алтайн боловсролын чанарыг сайжруулахад оршино.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтууд

1. Багшийн ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулна.

- 35
2. Багшийг эрдэмжүүлэн хөгжүүлнэ.
 3. Багшийн манлайллыг нэмэгдүүлнэ.
 4. Багшийн нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1 Багшийн ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд:

- 5.1.1. Ерөнхий боловсролын сургуулиудыг байгалийн ухааны лаборатори сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангана.
- 5.1.2. Цэцэрлэгүүдийг хүүхэд хөгжлийн танхимтай болоход дэмжлэг үзүүлнэ.
- 5.1.3. Сургууль бүрт “Багш хөгжлийн төв”-ийг стандартын дагуу байгуулж, багшид ээлтэй орчинг бүрдүүлнэ.
- 5.1.4. Багшийн хөгжлийн ордон байгуулна.
- 5.1.5. Сургууль, цэцэрлэгүүдийг цахим сүлжээнд бүрэн холбоно.
- 5.1.6. Багш нарын мэргэжлийн онолын мэдлэгийг сайжруулах цахим болон хэвлэмэл номын санг байгуулна.
- 5.1.7. Хэрэгцээнд үндэслэсэн сургууль, цэцэрлэгийн тэтгэлэгт төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 5.1.8. Алсын зайн сургалт, онлайн шалгалт явуулах орчин нөхцөл бүрдүүлж, тоног төхөөрөмжөөр хангана.

5.2. Багшийг эрдэмжүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд:

- 5.2.1. Гадаад болон дотоодод эрдмийн зэрэг, цол хамгаалсан багшийн тоог нэмэгдүүлнэ.
- 5.2.2. Багш нарын дунд эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг тогтмол зохион байгуулж, тэдний бүтээл, туурвил, ном зохиолыг хэвлэн нийтэлж олны хүртээл болгох, түгээн дэлгэрүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 5.2.3. Багш нарыг дотоод, гадаадын орнуудад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 5.2.4. Цэцэрлэгийн багш нарыг 100 хувь мэргэжлийн багшаар хангана.
- 5.2.5. Аймгаас төрж гарсан эрдэмтэд, судлаачид болон багш нарыг түшиглэн “Алтай судлалын төв”-ийг байгуулж, судалгааны үр дүнг сургалтад ашиглана.
- 5.2.6. Эрдэмтэн багш нар болон боловсролын тэргүүлэх мэргэжилтнүүдийг орон нутагтаа ажиллуулж, үйл ажиллагааны залгамж холбоог сайжруулна.

5.3. Багшийн манлайллыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

- 5.3.1. Сургууль, цэцэрлэгийг мэргэжлийн багшлах боловсон хүчнээр 100 хувь хангана.
- 5.3.2. Тусгай хэрэгцээт боловсролын багшийг бэлтгэж, гоц авьяастай болон хөгжлийн бэрхшээлтэй, сурлагаар хоцрогдож буй хүүхдүүдийн хөгжих боломжийг бүрдүүлнэ.
- 5.3.3. Багшийн онолын мэдлэгийн түвшинг жил бүр тогтоож, ахицыг тооцно.
- 5.3.4. Багшийн EQ, CQ, DQ, MQ чадварыг хөгжүүлэх үе шаттай ажлуудыг зохион байгуулна.
- 5.3.5. Багш нарын “Баг” олимпиадыг зохион байгуулна.
- 5.3.6. “Боловсролын цаг” нэвтрүүлгийг бий болгож, орон нутгийн телевизээр боловсролын үйл ажиллагааг сурталчилна.
- 5.3.7. “Алтайн багш” сонинг улирал тутамд гаргана.
- 5.3.8. Сургалтын байгууллага бүр дээр багшийн ажлын “Гүйцэтгэлийн менежментийн баг”-ийг ажиллуулж, “Хөгжсөн багшийн шалгуур үзүүлэлт”-ийн дагуу багшийн ажлын чанар үр дүнг тооцож, гэрчилгээжүүлнэ.
- 5.3.9. Ёс зүйн зөрчилгүй багш, заах аргын нэгдэл, хамт олныг шалгаруулж туршлагыг түгээн дэлгэрүүлж сурталчилна.
- 5.3.10. Багшийн бүтээл, шинэ санаа санаачилга, инновацийг дэмжинэ.

5.1.1	Сургуулиудыг байгалийн ухааны лаборатори, хэрэглэгдэхүүнээр хангана.	132	8	8	3	3	154
5.1.2	Сургууль, цэцэрлэгийн багш хөгжлийн төвийн багц хэрэглэгдэхүүний тоо	-	11	14	14	14	53
5.1.5	Интернэтийн сүлжээнд холбогдсон цэцэрлэг, сургуулийн тоо	25	8	8	8	8	57
5.1.6	Мэргэжлийн онолын мэдлэгийн цахим болон хэвлэмэл номын тоо	200	200	200	200	200	1000
5.1.7	Ерөнхий боловсролын сургуулиудад тэтгэлэгт төслүүдийг хэрэгжүүлж сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	126.3 сая	88.8	20.0	20.0	20.0	275.1 сая төг
5.1.8	Алсын зайн сургалт, онлайн шалгалт явуулах танхимын тоо	1	4	4	4	4	17
5.2.1	Гадаад дотоодод докторын зэрэг хамгаалсан багшийн тоо	-	2	2	2	2	8
5.2.1	Гадаад дотоодод магистр зэрэг хамгаалсан багшийн тоо	244	10	10	10	10	284
5.2.2	Онол практикийн хурлын тоо	-	1	1	1	1	4
5.2.2	Эмхэтгэж, нийтийн хүртээл болгосон багшийн шилдэг судалгааны бүтээлийн тоо	1	10	10	10	10	41
5.2.3	Гадаад болон дотоодод туршлага судалсан багшийн тоо	76	100	100	100	100	476
5.2.4	Бакалавр зэрэгтэй болсон багшийн тоо	104	7	7	7	7	132
5.2.5	Хамтарсан судалгааны дүнг сургалтад туршсан байдал	2	8	8	8	8	34
5.3.2	Тусгай хэрэгцээт боловсролын багшийн тоо	-	10	5	5	-	20
5.3.3	Багш нарын онолын мэдлэгийн түвшингийн ахиц	55%	58%	60%	65%	70%	70%
5.3.4	Багшийн EQ, CQ, DQ, MQ чадварын ахицаар үнэлнэ.						70%
5.3.5	Баг олимпиадын тоо	3	4	4	4	2	17
5.3.6	Орон нутгийн телевизээр нэвтрүүлсэн нэвтрүүлгийн тоо	0	10	60	52	52	174
5.3.7	"Алтайн багш" сонинг хэвлэж түгээсэн тоо		500	1000	1000	1000	3500
5.3.12	Хөрвөхөөр сурсан багшийн тоо	54	5	10	10	5	84
5.3.13	Сургалтын үр дүнг дүгнэсэн бүтээлч ажлын тоо	4	5	10	10	55	84
5.4.2	"Сургалт-хөдөлмөр-амралт" арга хэмжээний тоо	-	1	4	4	4	13
5.4.4	Багшид гэр бүлийн хэрэгцээний газар олгох	20%	5%	5%	5%	5%	40%

ажлыг зохион байгуулна.							
-------------------------	--	--	--	--	--	--	--

10.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх чанарын үзүүлэлт:

5.1.2 “Багшийн хөгжлийн ордон”-ыг байгуулж, ашиглалтад оруулсан байна.

5.1.7 Бага боловсролын чанарын ахицын үзүүлэлтээр сургуулийн тэтгэлэгт төслүүдийн үр дүнг тооцно.

5.2.5 Ахмад, дунд, залуу үеийн багш нарын хамтран ажилласан туршлага зохион байгуулсан арга хэмжээ, үр дүнгээр тооцно.

5.3.8. Сургалтын байгууллага бүр дээр багшийн ажлын “Гүйцэтгэлийн менежментийн баг”-ийг ажиллуулж, “Хөгжсөн багшийн шалгуур үзүүлэлт”-ийн дагуу багшийн ажлын чанар үр дүнг тооцож, гэрчилгээжүүлэн, багшийн ахиц амжилтыг баталгаажуулсан байна.

5.3.9. Ёс зүйн зөрчилгүй багш, заах аргын нэгдэл, хамт олныг шалгаруулж туршлагыг түгээн дэлгэрүүлж, ёс зүйн зөрчлийг бууруулсан байна.

5.3.10. Багшийн бүтээл, шинэ санаа санаачилга, инновацийг дэмжиж “Бүтээлч багш”-ийг шалгаруулна.

5.4.1. Багшийг мэргэжлээс шалтгаалах өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт оношлуулах эмчилгээнд хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж өвчлөлийг бууруулж, эрүүлжүүлсэн байдлаар үнэлэгдэнэ.

5.4.2. Сургалт-хөдөлмөр-амралт үйл ажиллагааг зохион байгуулсан байдал үр дүнгээр үнэлэгдэнэ.

5.4.4. Оны шилдэг багш шалгаруулах ёслол хүндэтгэлийн арга хэмжээг жил бүр зохион байгуулж, шагнаж, урамшуулсан байна.

"БАГШИЙН ХӨГЖИЛ" ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хөтөлбөрийн зорилтыг хангах үйл ажиллагаа	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийг хангах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Тоо хэмжээ	Нэгж арга хэмжээний зардал	Төсөв санхүү (мянган төгрөг)	Санхүүгийн эх үүсвэр
1	54.1.1	Хөхморьт, 2-р сургууль, 3-р сургууль, Гуулингийн сургууль, Алтай, Дэлгэр, Тайшир 8-р цэцэрлэгийг дуу хөгжмийн кабинеттай болгоно.	2017-2018 он	Хичээл сургалт үр дүнтэй явагдах багш хөгжих боломж бүрдэнэ	БСУГ	БСУГ, Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	8	5800.0	46400.0	Улсын төсөв, орон нутгийн төсөв
2		Баян-Уул, Дарив, Дэлгэр, Тайшир, Шарга, Цээл сумдын сургуулиудыг химийн лаборатори, урвалж бодисоор хангана.	2017-2018 он		БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	6	9000.0	54000.0	Улсын төсөв, орон нутгийн төсөв
3		Дарив, Эрдэнэ, Баян-Уул, Дэлгэр, Тайшир, Цээл сумдын сургуулиудыг физикийн лаборатори урвалж бодистой болгоно.	2017-2018 он		БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	6	9000.0	54000.0	Улсын төсөв, орон нутгийн төсөв
4		24 сургууль, 7 цэцэрлэгийг биеийн тамирын багц хэрэглэгдэхүүнээр хангана.	2017-2018 он		БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	31	7600.0	235600.0	Улсын төсөв, орон нутгийн төсөв
5		Тонхил, Хөхморьт сумын сургуулийг технологийн кабинеттай болгоно.	2017-2018 он		БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	2	10000.0	20000.0	Улсын төсөв, орон нутгийн төсөв
6		Баян-Уул, Дэлгэр, 2-р сургуулийг биологийн кабинеттай болгоно.	2017-2018 он		БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	3	9000.0	27000.0	Улсын төсөв, орон нутгийн төсөв
7		25 сургууль, 28 цэцэрлэгийн багш хөгжлийн төвийг стандартын дагуу байгуулж, гэрчилгээжүүлнэ.	2017-2018 он	Багш хөгжлийн төвийн тоног төхөөрөмж нэмэгдсэнээр багшийн ажлын байрандаа хөгжих боломж нэмэгдэнэ.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	53	4000.0	212000.0	Улсын төсөв, орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр

5/18

8	5.1.5	Алтай чуулгын хуучин барилгыг засварлан багш хөгжлийн ордон байгуулна.	2017-2020 он	Багш хөгжлийн ордон байгуулагдсанаар багш хөгжих тогтолцоо	АЗДТГ НБХ	БСУГ			840000.0	Улсын төсвөөс
9	5.1.6	Мэргэжлийн онолын мэдлэгийн цахим болон хэвлэмэл номын санг байгуулна.	2017-2019 он	Багшийн онолын мэдлэг сайжирна.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	2	5000.0	10000.0	Төсөл, хөтөлбөр, хандив тусламж
10	5.1.7	Хэрэгцээнд суурилсан сургууль, цэцэрлэгүүдийн тэтгэлэгт төслүүдийг хэрэгжүүлнэ.	2017-2020 он	Сургалтын хэрэглэгдэхүүн нэмэгдэнэ.	БСУГ	БСШУСЯ			215000.0	Төсөл, хөтөлбөрөөс
11	5.1.8	Баруун бүсийн TOFEL-ийн шалгалтад бэлтгэх танхимыг байгуулна.	2017-2020 он	Гадаадын их дээд сургуульд суралцах боломж бүрдэнэ.	БСУГ	Олон улсын TOFEL-ийн төв	1		5000.0	Төсөл хөтөлбөрөөс
12	5.1.9	Онлайн шалгалтын төв	2017-2020 он	Төрөл бүрийн шалгалтыг онлайнгаар зохион байгуулах боломж бүрдэнэ.	БСУГ	БСШУСЯ	1		20000.0	Улсын төсвөөс

13	5.2.1	Багш нарыг гадаад дотоодод докторын зэрэг хамгаалуулна.	2017-2020 он	Эрдэмтэн багшийн тоо нэмэгдэнэ.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	6	7000.0	42000.0	ОНХС, багшийн оролцоо төсөл
14		Багш нарыг гадаад дотоодод магистр зэрэг хамгаалуулна.	2017-2020 он	Судлаач багшийн тоо нэмэгдэнэ.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	30	3000.0	90000.0	СӨБ, ЕБС, багшийн оролцоо
15	5.2.2	Онол практикийн бага хурлыг зохион байгуулна.	2017-2020 он	Багш нарын судалгаа шинжилгээний ажил чанаржина.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	4	1200.0	4800.0	ОНХС, Төсөл хөтөлбөр
16		Багш нарын шилдэг судалгааны бүтээлийг эмхэтгэж сурталчилна.	2017-2020 он	Багш нарын судалгааны ажлыг түгээн дэлгэрүүлнэ.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	400	25.0	10000.0	ОНХС, Төсөл хөтөлбөр, Улсын төсөв

17	5.2.3	Гадаад улс орнуудад туршлага судлах ажлыг зохион байгуулна.	2017-2020 он	Харилцан туршлага солилцож, шилдэг тэргүүний туршлагыг нутагшуулна.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	180	120.0	21600.0	ОНХС, Төсөл хөтөлбөр, Улсын төсөв
18		Дотоодод туршлага судлах ажлыг зохион байгуулна.	2017-2020 он	Харилцан туршлага солилцож, шилдэг тэргүүний туршлагыг нутагшуулна.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	300	80	24000.0	Улсын төсөв, ОНХС, Төсөл хөтөлбөр
19	5.2.4	Цэцэрлэгийн багш нарыг бакалавр зэрэгтэй болгоно.	2017-2020 он	Цэцэрлэгүүд 100 хувь мэргэжлийн багшаар хангагдана.	БСУГ	Сумдын цэцэрлэг	28	1500	42000.0	СӨБ, багшийн оролцоо
20	5.2.5	Аймгаас төрж гарсан эрдэмтэд, судлаачид болон багш нарыг түшиглэн "Алтай судлалын төв"-ийг байгуулна.	2017-2018 он	Судалгаа шинжилгээний төвтэй болж, Алтай судлалыг хөгжүүлнэ.	БСУГ	ЗДТГ	1	5000.0	5000.0	ОНХС, Төсөл хөтөлбөр
21	5.3.2	Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх	2017-2018 он	Боловсролын хүртээмж нэмэгдэнэ.	БСУГ	АЗДТГ, НБХ	4	7500.0	30000.0	ОНХС, Төсөл хөтөлбөр
22	5.3.3	Багш нарын онолын мэдлэгийн түвшин тогтооно.	2017-2020 он		БСУГ		6	1500.0	9000.0	ОНХС, Төсөл хөтөлбөр
23	5.3.4	Багшийн EQ, EQ,CQ, DQ, MQ чадварын сорилыг зохион байгуулна.	2017-2019 он	Багш бүх талаар хөгжинө.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	940	1.5	1410.0	ЕБС, СӨБ-ийн төсөв
24	5.3.4	Багшийн EQ, EQ,CQ, DQ, MQ чадварын сургалтуудыг зохион байгуулна	2017-2020 он	Багш хүний хөгжлийн цогц мэдлэг чадварыг эзэмшинэ.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	940	3.8	3572.0	ЕБС, СӨБ-ийн төсөв

250

25	5.3.5	Багш нарын "Баг" олимпиадыг зохион байгуулна.	2018-2020 он	Багш нар багаар хөгжинө.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	3	7100.0	21300.0	Орон нутгийн хөгжлийн сан, Төсөл хөтөлбөр
26	5.3.6	Орон нутгийн болон үндэсний хэмжээнд "Боловсролын цаг"-ийг бий болгож үйл ажиллагааг тогтмолжуулна.	2017-2020 он	Боловсролын салбарын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	72	70.0	5040.0	ЕБС, СӨБ-ийн төсөв, Улсын төсөв, ОНХС
27	5.3.7	"Алтайн багш" сонинг улирал тутамд гаргана.	2017-2020 он		БСУГ		36	1250.0	45000.0	ОНХС, Төсөл хөтөлбөр
28	5.3.8	Сургалтын байгууллага бүр дээр багшийн ажлын "Гүйцэтгэлийн менежментийн баг"-ийг ажиллуулж, "Хөгжсөн багшийн шалгуур үзүүлэлт"-ийн дагуу багшийн ажлын чанар үр дүнг тооцож гэрчилгээжүүлнэ.	2017-2019 он	Багшийн хөгжлийн ахиц амжилтыг тооцно.	БСУГ	Сумдын ЗДТГ ЕБС цэцэрлэг	30	200.0	6000.0	ОНХС, Төсөл хөтөлбөр
29	5.3.9	Ёс зүйн зөрчилгүй багш, заах аргын нэгдэл, хамт олныг шалгаруулж туршлагыг түгээн дэлгэрүүлж сурталчилна.	2017-2020 он	Багшийн ёс зүйн зөрчил багасна.	БСУГ	ЕБС цэцэрлэг	30	200.0	6000.0	Улсын төсөв, ОНХС, Төсөл хөтөлбөр
30	5.3.11	Багшийн бүтээл, шинэ санаа санаачилга, инновацийг дэмжинэ.	2017-2020 он	Бүтээлч багшийн тоо нэмэгдэнэ.	БСУГ	ЕБС цэцэрлэг	15	200.0	3000.0	ОНХС, Төсөл хөтөлбөр
31	5.3.10	Багшийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт оношлуулах эмчилгээнд хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	2017-2019 он	Багшийн өвчлөл буурч эрүүлжинэ.	БСУГ	ЭМГ Нэгдсэн эмнэлэг ЕБС цэцэрлэг	3	9400.0	28200.0	ЕБС, СӨБ, багшийн оролцоо багш нар
32		Эрүүл багшаас-Бүтээлч	2017-2020 он	Багшийг өвчлөлөөс		АЗД, НБХ	3	20000.0	60000.0	Орон нутгийн хөгжлийн сан

33	5.4.2	ухаан арга хэмжээг зохион байгуулна.	2017-2019 он	сэргийлж эрүүлжүүлнэ.	БСУГ	ЕБС цэцэрлэг сургууль	940	40.0	37600.0	Багшийн оролцоо
34	5.4.3	Олон улс, улсын уралдаанд амжилт гаргасан багшийг урамшуулна.	2017-2020 он	Багшийг урамшуулах тогтолцоо	БСУГ	АЗДТГ, НБХ	12	1000.0	12000.0	Орон нутгийн хөгжлийн сан
35	5.4.4	Оны шилдэг багш шалгаруулах ёслол хүндэтгэлийн арга хэмжээг жил бүр зохион байгуулж шагналын шинэ хэлбэрийг бий болгож урамшуулна.	2017-2020 он	Багшийн нэр хүнд үнэлэмж нэмэгдэнэ.	БСУГ	АЗД, НБХ ЕБС цэцэрлэг сургууль	4	5000.0	20000.0	ОНХС, Төсөл хөтөлбөр, Ивээн тэтгэгч олох
36	4.4.4	Багшид гэр бүлийн хэрэгцээний газар олгоно.	2017-2020 он	Нийгмийн баталгаагаар хангагдана.		Аймаг сумдын ИТХ, ЗД, - ГХБХБГ	150	0.0	0.0	-
Нийт шаардагдах зардал									2212522.0	

Нийт хөрөнгийн эх үүсвэрийн задаргаа

/ Мян.төг /

№		2017	2018	2019	2020	Нийт
1	Багшийн оролцоо	58350.0	65350.0	65350.0	60650.0	249700.0
2	Хандив тусламж	500.0	5500.0	5000.0	5000.0	16000.0
3	Төсөл хөтөлбөр	10000.0	25000.0	25000.0	25000.0	85000.0
4	БСУГ-ын төсөв	2500.0	2500.0	2500.0	2500.0	10000.0
5	Улсын төсөв, Орон нутгийн төсөв	329000.0	1149000.0	188000.0	58000.0	1724000.0
6	Орон нутгийн төсөв	7205.5	7205.5	7205.5	2505.5	24122.0
7	Орон нутгийн хөгжлийн сан	52675.0	56675.0	39175.0	35175.0	183700.0
	Нийт	460230.5	1311230.5	332230.5	188830.5	2292522.0

-----000-----

127